



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Тушаал шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 30 дугаар зүйлийн 30.1, 30.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.


2.Итгэмжлэлийн техникийн хороо болон итгэмжлэлийн шинжээчийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэхийг Үндэсний итгэмжлэлийн төв (С.Ням-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Хавсралтад заасан төлбөрийн хэмжээг мөрдөж, үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Үндэсний итгэмжлэлийн төв (С.Ням-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны даргад даалгасугай.

5.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



С.АМАРСАЙХАН

0025100665

Монгол Улсын Шадар сайдын
2025 оны 04 дугаар сарын 25-ны
өдрийн 17 дугаар тушаалын
хавсралт

**Тохирлын үнэлгээний итгэмжлэлийн ажил
үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ**

№	Төлбөрийн төрөл	Төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)		
1.	Итгэмжлэлийн өргөдөл, баримт бичигт үзлэг, дүн шинжилгээ хийх төлбөр			
	Анхдагч итгэмжлэлийн	240 000 V		
	Давтан итгэмжлэлийн	160 000 V		
	Хүрээ өргөтгөх	100 000 V		
	Сорилт, шалгалт тохируулга, баталгаажуулалт, хяналтын төрлийн тооноос хамаарах коэффициент:	Анхдагч	Давтан	Хүрээ өргөтгөх
	1-3 төрөлд V=1	240 000	160 000	100 000
	4-6 төрөлд V=1,5	360 000	240 000	150 000
	7-9 төрөлд V=2	480 000	320 000	200 000
	10 ба түүнээс дээш	600 000	400 000	250 000
2.	Анхдагч, урьдчилсан, давтан, дагалдах, магадлах итгэмжлэлийн хүрээ өргөтгөх газар дээрх итгэмжлэлийн үнэлгээний төлбөр	N*(D+1)*80000 төг N-тухайн ТҮБ-ын газар дээр нь ажилласан үнэлгээний мэргэжилтний тоо D-газар дээр нь ажилласан өдрийн тоо 80000-нэг үнэлгээний ажилтны үнэлгээ хийх нэг хүн/өдрийн зардал		
	Үйлчлүүлэгч тохирлын үнэлгээний байгууллага нь итгэмжлэлийн үнэлгээний ажлын хэсгийн томилолтын болон замын зардлыг хариуцна.			
3.	Итгэмжлэлийн гэрчилгээ, тэмдэг хэрэглэсний болон итгэмжлэлийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний төлбөр	250 000 * K		
	Сорилтын лаборатори, эмнэлгийн лаборатори, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын лаборатори, аж ахуйн нэгж байгууллага Ажилтны тоо			
	3 хүртэл бол K=2	500 000 * V		
	4-7 бол K=3	750 000 * V		
	8-15 бол K=4	1 000 000 * V		
	16-40 бол K=5	1 250 000 * V		
	41-100 бол K=6	1 500 000 * V		
	100-аас олон бол K=7	1 750 000 * V		
	Хяналтын байгууллага Ажилтны тоо			
	3 хүртэл бол K=2	500 000 * V		
	4-7 бол K=3	750 000 * V		

	8-15 бол K=4 16-40 бол K=5 41-100 бол K=6 100-аас олон бол K=7	1 000 000 * V 1 250 000 * V 1 500 000 * V 1 750 000 * V
	Баталгаажуулалт/гэрчилгээжүүлэлтийн байгууллага Ажилтны тоо 3 хүртэл бол K=3 4-7 бол K=4 8-15 бол K=5 16-40 бол K=6 41-100 бол K=7 100-аас олон бол K=8	750 000 * V 1 000 000 * V 1 250 000 * V 1 500 000 * V 1 750 000 * V 2 000 000 * V
	Байгаль орчны мэдээллийн магадалгаа, нотолгооны байгууллага 3 хүртэл бол K=3 4-7 бол K=4 8-15 бол K=5 16-40 бол K=6 41-100 бол K=7 100-аас олон бол K=8	750 000 * V 1 000 000 * V 1 250 000 * V 1 500 000 * V 1 750 000 * V 2 000 000 * V
4.	Итгэмжлэлийн гэрчилгээний нэмэлт хувь, монгол ба англи хэл дээр (тохирлын үнэлгээний байгууллагын хүсэлтээр), нэг хувь	20 000
5.	Олон улсын итгэмжлэлийн байгууллагын харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийн хүрээнд итгэмжлэлийн хосолсон тэмдгийг хэрэглэх дэд лицензийн жилийн төлбөр	1 700 000 * V